



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА



Улаанбаатар хот

2022



## МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

2022 оны 3 дугаар сар.

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн:

Ашигт малтмал, газрын тосны газрын

Уул уурхай, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Уул уурхай, судалгааны хэлтсийн мэргэжилтэн

Г.Дөл

Ашигт малтмал, газрын тосны газар  
Монгол Улс, Улаанбаатар хот 15170,  
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,  
Засгийн газрын XII байр, Баруун жигүүр  
Утас: 976-51-263934

Цахим шуудан: [info@mrpam.gov.mn](mailto:info@mrpam.gov.mn)

Цахим хаяг: [mrpam.gov.mn](http://mrpam.gov.mn)

## АГУУЛГА

<b>1. УДИРТГАЛ</b>	<b>5</b>
1.1. Судалгааны хамрах хүрээ	5
1.2. Судалгааны арга	7
1.2.1. Судалгааны асуулт	7
<b>2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН</b>	<b>9</b>
<b>3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>10</b>
3.1. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломж	10
3.2. Геологи, хайгуулын ажлын үнэмшил	11
3.3. Улс төрийн тогтвортой байдал	13
3.4. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдал	14
3.5. Байгаль орчны хууль, дүрмийн тодорхой байдал	16
3.6. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдал	17
3.7. Уул уурхайн татварын орчин	18
3.8. Дэд бүтцийн хөгжил	19
3.9. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал	21
3.10. Амьдрах орчны аюулгүй байдал	23
3.11. Газрын харилцааны зохицуулалтын байдал	24
3.12. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөө	<b>ERROR! BOOKMARK NOT DEFINED.</b>
3.13. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж	27
3.14. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцаа	29
3.15. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал	30
3.16. Нийгмээс уул уурхайд хандах хандлага	32
3.17. Авлигаас ангид байдал	33
3.18. Туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанар	35
3.19. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж	35
<b>4. ДҮГНЭЛТ</b>	<b>37</b>
<b>5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>39</b>

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийг сайжруулах санал	11
Хүснэгт 2. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлыг сайжруулах санал	12
Хүснэгт 3. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал	14
Хүснэгт 4. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал	15
Хүснэгт 5. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал	17
Хүснэгт 6. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдлыг сайжруулах санал	18
Хүснэгт 7. Уул уурхайн татварын орчныг сайжруулах санал	19
Хүснэгт 8. Дэд бүтцийг хөгжүүлэх санал	20
Хүснэгт 9. Мэргэжлийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх санал	22
Хүснэгт 10. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал	24
Хүснэгт 11. Газрын харилцааны зохицуулалтыг сайжруулах санал	25
Хүснэгт 12. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөг сайжруулах санал	27
Хүснэгт 13. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал	28
Хүснэгт 14. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааг сайжруулах санал	30
Хүснэгт 15. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах ажиллагааг хялбаршуулах санал	31
Хүснэгт 16. Нийгмээс уул уурхайд хандах хандлагыг сайжруулах санал	33
Хүснэгт 17. Авлигаас ангид байлгах санал	34
Хүснэгт 18. Туслан гүйцэтгэгчийн чадавхийг нэмэгдүүлэх санал	<b>Error! Bookmark not defined.</b>
Хүснэгт 19.. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал	<b>Error! Bookmark not defined.</b>

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйл ажиллааны чиглэл .....	5
Зураг 2. Хөрөнгө оруулалт оруулсан хэлбэр .....	6
Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил .....	6
Зураг 4. Ашигт малтмалын төрөл .....	7
Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ .....	9
Зураг 6. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийн үнэлгээ .....	10
Зураг 7. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлын үнэлгээ .....	12
Зураг 8. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ .....	13
Зураг 9. Уул уурхайн хууль дүрмийн тодорхой байдал .....	15
Зураг 10. Байгаль орчны хууль дүрмийн тодорхой байдал .....	16
Зураг 11. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдал .....	17
Зураг 12. Уул уурхайн татварын орчин .....	18
Зураг 13. Дэд бүтцийн хөгжил .....	20
Зураг 14. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал .....	21
Зураг 15. Амьдрах орчны аюулгүй байдал .....	23
Зураг 16. Газрын харилцааны зохицуулалтын байдал .....	24
Зураг 17. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ .....	26
Зураг 18. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ .....	27
Зураг 19. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааны үнэлгээ .....	29
Зураг 20. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ .....	30
Зураг 21. Нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ .....	32
Зураг 22. Авлигаас ангид байдлын үнэлгээ .....	33
Зураг 23. Туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ .....	35
Зураг 24. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ .....	36

## 1. УДИРТГАЛ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах

### 1.1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Хөрөнгө оруулалтын орчны судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг чиглэл тус бүрийн байгууллагуудыг хамруулахыг зорьсон бөгөөд нийт 121 байгууллага хамрагдсан.




Зураг 1. Үйл ажиллааны чиглэл

Судалгаанд оролцсон байгууллагуудаас ашигт малтмалын геологийн эрэл, хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 87.6% нь байсан бол боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, банк санхүү, хуулийн фирм, салбарын төрийн бус байгууллагууд үлдсэн хэсгийг нь бүрдүүлсэн.


Дээрх байгууллагуудын хөрөнгө оруулалт оруулсан байдлыг авч үзвэл ихэнх хэсэг өөрийн хөрөнгийг төсөлдөө зарцуулсан байхад тавны нэг нь гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж, 9.1% нь банк санхүүгийн байгууллагаас зээл авч, үлдсэн 6.6% нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож, бусад байдлаар 5% нь хөрөнгө оруулжээ.

Зураг 2. Хөрөнгө оруулалт оруулсан хэлбэр




Үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд 4-өөс 10 жил болж байгаа компаниуд тал хувийг эзэлж, 11-аас 14 жил аж ахуй эрхэлж буй байгууллагууд 15.7%, байгуулагдаад удаагүй буюу 1-ээс 3 жил болж байгаа аж ахуйн нэгж 20.7%, 15-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагажсан байгууллагууд 12.4 %-ийг тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил



Зураг 4. Ашигт малтмалын төрөл



Алтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамгийн их хувь буюу 41.3%-ийг эзэлж, дараагаар нь нүүрсний уурхай 14.9%, хайлуур жоншны уурхай 14%, барилгын материал үйлдвэрлэгчид 6.6%-ийг бүрдүүлсэн. Үлдсэн хэсгийг нь зэс, төмөр, гянтболд, цайр, хар тугалга болон бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүрдүүлсэн байна.

## 1.2. СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны ажлыг асуулга /анкет, асуумж/-ын аргаар авч, хөрөнгө оруулалтын орчны чиглэлийн асуултуудад үнэлгээ өгөх байдлаар хариултуудыг авч тухайн асуудлыг сайжруулах арга замын талаар санал авлаа.

### 1.2.1. Судалгааны асуулт

Судалгааны асуулга нийтдээ 26 асуулттай бөгөөд үүнээс 5 асуулт нь ерөнхий мэдээлэл авах асуулт, үлдсэн 21 нь үндсэн асуулт байсан. Үндсэн асуултуудаас 19 асуулт нь уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд үнэлгээ өгөх хариулт болон сайжруулах саналыг авсан бол 1 асуулт нь өмнөх асуултуудад ороогүй чиглэл байвал санал өгч болохоор, 1 асуулт нь энэхүү судалгааны ажлыг цаашид сайжруулахад юу хийх талаар санал авахаар зохиогдсон. Асуултуудыг боловсруулахдаа олон улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг үнэлэхэд хэрэглэдэг үзүүлэлт болон манай орны нөхцөлд байдалд тохируулсан асуултыг бэлтгэсэн болно.

Хөрөнгө оруулалтын орчинг үнэлж өгч, сайжруулах санал өгөх асуултууд:

1. Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж
2. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал
3. Улс төрийн тогтвортой байдал
4. Уул уурхайн үйл ажиллагааны хууль, дүрмийн тодорхой байдал
5. Байгаль орчны хууль, дүрэм, журмын тодорхой байдал
6. Хөрөнгө оруулагчийн хууль, ёсны эрх ашгийг хамгаалсан байдал
7. Уул уурхайн татварын орчин
8. Дэд бүтцийн хөгжил
9. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал
10. Амьдрах орчны аюулгүй байдал
11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал
12. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөө
13. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж
14. Нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хоорондын харилцаа
15. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал
16. Нийгмээс уул уурхайд хандаж буй хандлага
17. Авлигаас ангид байдал
18. Туслан гүйцэтгэгчийн хүртээмжтэй байдал, чанар
19. Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж

Санал асуулгад оролцогч нь дээрх 19 үзүүлэлт тус бүрт өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж одоогийн байдлыг бодолцон үзэж дараах 5 хариултын аль нэгийг сонгож үнэлэлт өгөхөөр зохицуулсан.

1. Маш муу
2. Муу
3. Дунд зэрэг
4. Сайн
5. Маш сайн

Асуулгын хариултыг интернетийн орчинд, биечлэн шууд асуултыг бөглөх зэрэг хэлбэрээр хүлээн авсан.

Судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 1200 гаруй байгууллагыг хамруулахыг зорьсон боловч цахим хаяг ашиглагдахгүй болсон, холбоо барих утас нь буруу зэрэг шалтгаанаас болж асуулга хүргэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд 121 байгууллага судалгаанд оролцож, асуулгад хариулт ирүүлжээ.

## 2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд 100 хүртэлх оноогоор үнэлэлт өгсөн. Судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хариултыг үнэлгээ тус бүрийн хувийн жинг гаргаж, жигнэсэн дундаж гаргах байдлаар тооцоолж нэгдсэн үнэлгээг тодорхойлсон.

Үнэлгээний 5 категори нь 100 онооны системд дараах онооны интервалтай байхаар тооцоолсон.

- маш муу үнэлгээ нь 34 хүртэл оноо,
- муу үнэлгээ нь 34-өөс 50 оноо,
- дунд үнэлгээ нь 50-иас 66 оноо,
- сайн үнэлгээ нь 66-гаас 84 оноо,
- маш сайн үнэлгээ нь 84-өөс дээш оноо

Энэ жилийн хувьд нэгдсэн дүнгээр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин **54.1** оноо авч **“Дунд зэрэг”** гэсэн дүнтэй гарсан байна. Судалгааны асуултуудаас маш сайн, сайн, маш муу үзүүлэлттэй асуулт гараагүй бөгөөд дунд ангилалд 13 үзүүлэлт, муу ангилалд 7 үзүүлэлт хамрагдав.

Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ



Хамгийн өндөр оноо авсан нь Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүртээмжтэй болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар /64.8 оноо/, Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал /64.6 оноо/ байсан бол Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал /61.2 оноо/, Уул уурхайн үйл ажиллагааны хууль, дүрмийн тодорхой байдал /60.7

оноо/, Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж /58.7 оноо/ Уул уурхайн татварын орчин /58.7 оноо/, Байгаль орчны хууль, дүрэм, журмын тодорхой байдал /57.2 оноо/, Амьдрах орчны аюулгүй байдал /56.5 оноо/, Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /55.7 оноо/ гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Харин Төрийн байгууллагын харилцаа, хандлага /55.7 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /53.6 оноо/, Авлигаас ангид байдал /52.6 оноо/, Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал /52.2 оноо/ үзүүлэлт нь дунд ангилалдаа доогуур жагсжээ.


Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Улс төрийн тогтвортой байдал /44.1 оноо/ бол үүний дараа Нийгмээс уул уурхайд хандаж буй хандлага /44.8 оноо/ орсон. Дараагийн төвшний тааруухан үзүүлэлт нь Дэд бүтцийн хөгжил /46.1 оноо/, Нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хоорондын харилцаа /46.3 оноо/ байсан бол муу ангилал дотроо арай гайгүй үзүүлэлттэй байгаа нь Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /48.6 оноо/, Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөө /48.9 оноо/ байв.

### 3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### 3.1. ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ ХЯЛБАР ОЛЖ АВАХ БОЛОМЖ


Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологийн мэдээлэл хялбар авах боломж дунджаас дээгүүр буюу 58.7% байна. Нийт судалгаанд оролцогсодын 60.3% нь дунд зэрэг, 18.2% нь сайн, 14.9% нь муу, 5.8% нь маш сайн, 0.8% нь маш муу гэж хариулсан байна.

Зураг 6. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийн үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад боломжийн 23 , мэдээллийн сан , сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах 22, нээлттэй, ил тод болгох 22, түгээлтийн сувгийг өргөжүүлэх 19, цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох 6, төлбөр үнэтэй 1 гэх мэт хариулт өгчээ.

Зураг 6.1. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг Мэдээллийн сан, сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах , Нээлттэй, ил тод болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.2. ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮНЭМШИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологи, хайгуулын ажлын үнэмшил сайн буюу 64.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 59.5% нь дунд зэрэг, 30.6% нь сайн, 5.8% нь муу, 1.7% нь маш сайн, 2.5% нь маш муу гэж хариулсан байна.

Зураг 7. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлын үнэлгэ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 16 аж ахуй нэгж хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх, 6 аж ахуй нэгж мэргэжлийн байгууллагыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, 5 аж ахуй нэгж ил тод, цахим болгох, 2 аж ахуй нэгж сургалт, гарын авлага, стандарт бий болгох, 1 аж ахуй нэгж мэргэжлийн хүнээр чанартай, нарийвчилж гүйцэтгэх гэсэн хариулт өгчээ.

Зураг 7.1. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлыг сайжруулах санал



Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 87.5%-ийг хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх гэсэн санал эзэлж байна.

### 3.3. УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ дунджаас доогуур буюу 44.1% байна. Нийт судалгаанд оролцогсодын 26.4% нь маш муу, 32.2% нь муу, 35.5% нь дунд зэрэг, 5.8% нь сайн, 0% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 8. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 9 аж ахуй нэгж бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, 8 аж ахуй нэгж ЗГ, төрийн байгууллага тогтвортой байх, тус бүр 3 аж ахуй нэгж мэргэшсэн мэргэжилтнүүд тогтвортой байх, иргэд, хөдөлгөөнийг зохицуулах, нийгмийн идэвхтэй байх, салбарыг улс төр, намаас ангид байлгах, хамаарлыг багасгах, 2 аж ахуй нэгж удирдах өндөр албан тушаалд мэргэжлийн хүнийг томилуулах гэх зэргээр хариулжээ.

Зураг 8.1 Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 30%-ийг бодлого, хууль эрх зүйн орчин тогтвортой байх гэсэн санал эзэлж байна.

### 3.4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ДҮРМИЙН ТОДОРХОЙ БАЙДАЛ


Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 60.7% байна. Нийт судалгаанд оролцогсодын 55.4% нь дунд зэрэг, 10.7% нь муу, 24.0% нь сайн, 7.4% нь маш муу, 2.5% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 9. Уул уурхайн хууль дүрмийн тодорхой байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 15 аж ахуй нэгж хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, 6 аж ахуй нэгж орон нутгийн эрх мэдлийг багасгах, орон нутгийн захирамж хуулиас илүү гардаг, тус бүр 2 аж ахуй нэгж сурталчлан таниулах, боломжийн байна 1 аж ахуй нэгж олон улсын жишиг судлах гэх зэргээр хариулжээ.

Зураг 9.1 Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 73.3%-ийг хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах гэсэн санал эзэлж байна.

### 3.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ДҮРМИЙН ТОДОРХОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд байгаль орчны хууль, дүрмийн тодорхой байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 57.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 53.7% нь дунд зэрэг, 18.2% нь сайн, 20.7% нь муу, 6.6% нь маш муу, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 10. Байгаль орчны хууль дүрмийн тодорхой байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 7 аж ахуй нэгж хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох, 5 аж ахуй нэгж хууль тогтоомжийг суртачилах, 4 аж ахуй нэгж ашиглалт, хайгуулыг ялгаж дүрэм журмыг өөрчлөх, 3 аж ахуй нэгж боломжийн, 2 аж ахуй нэгж Орон нутгийн эрх мэдлийг багасгах, орон нутгийн захирамж хуулиас илүү гардаг гэх зэргээр хариулжээ.

Зураг 10.1 Байгаль орчны хууль дүрэм, журмыг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 28.6%-ийг хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдлын үнэлгээ дунджаас доогуур буюу 48.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 43.8% нь дунд зэрэг, 27.3% нь муу, 19.8% нь маш муу, 8.3% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 11. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 12 аж ахуй нэгж хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, 5 аж ахуй нэгж мэдээлэл сурталчилгаа хийх, тус бүр 4 аж ахуй нэгж тодорхой, тогтвортой байх, хангалттай, 2 аж ахуй нэгж орон нутгийн удирдлагатай зөрчилтэй гэх мэтчилэн хариулжээ.

Зураг 11.1 Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдлыг сайжруулах санал



Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 44.4%-ийг хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах байх гэсэн санал эзэлж байна.

### 3.7. УУЛ УУРХАЙН ТАТВАРЫН ОРЧИН


Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн татварын орчны үнэлгээ дунджаас дээгүүр буюу 58.5% байна. Нийт судалгаанд оролцогсодын 43.1% нь дунд зэрэг, 33.1% нь сайн, 7.7% нь муу, 7.7% нь маш муу, 8.5% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 12 Уул уурхайн татварын орчин



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 7 аж ахуй нэгж АМНАТ-ыг бууруулах, 6 аж ахуй нэгж хууль эрх зүйн орчинг сайжруулах, 4 аж ахуй нэгж татварыг орчныг тогтвортой байлгах, тус бүр 2 аж ахуй нэгж хэрэгжилтийг сайжруулж, мэдээлэл сурталчилгаа хийх, Давхардуулж авахгүй байх гэх мэтээр хариулжээ.

Зураг 12.1 Уул уурхайн татварын орчныг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 33.3%-ийг АМНАТ-ыг бууруулах гэсэн санал эзэлж байна.

### 3.8. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд дэд бүтцийн хөгжлийн үнэлгээ дунджаас доогуур буюу 49.5%

байна. Нийт судалгаанд оролцогсодын 33.8% нь дунд зэрэг, 36.2% нь муу, 13.1% нь маш муу, 15.4% нь сайн, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 13. Дэд бүтцийн хөгжил



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 14 аж ахуй нэгж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тус бүр 7 аж ахуй нэгж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, төмөр зам барих, тус бүр 6 аж ахуй нэгж авто зам барих, засвар үйлчилгээг сайжруулах, дэд бүтцийн орчныг сайжруулах, 5 аж ахуй нэгж эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, 2 аж ахуй нэгж вагоны тоо, ТЗ-н нэвтрүүлэх чадварыг нэмэх, 1 аж ахуй нэгж төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх аж ахуй нэгж аж ахуй нэгж гэх мэтээр хариулжээ.

Зураг 13.1 Дэд бүтцийг хөгжүүлэх санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 29.2%-ийг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийг буюу 29.2%-ийг төмөр зам барих болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа гэсэн санал эзэлж байна.

### **3.9. МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭТЭЙ БАЙДАЛ**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 61.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 36.2% нь дунд зэрэг, 41.5% нь сайн, 16.9% нь муу, 3.8% нь маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.

*Зураг 14. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал*



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 16 аж ахуй нэгж хөдөлмөрийн үнэлэмжийг тодорхой болгох, 10 аж ахуй нэгж Боловсон хүчинг сайн бэлдэх, тус бүр 9 аж ахуй нэгж оюутны дадлагыг илүү үр дүнтэй болгох, мэргэжлийн сургалт зохион байгуулах, 4 аж ахуй нэгж ажиллах таатай орчинг бий болгох, 2 аж ахуй нэгж ажлын байр нэмэгдүүлэх гэх мэтээр хариулжээ.

Зураг 14.1. Мэргэжлийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 32.0%-ийг хөдөлмөрийн үнэлэмжийг тодорхой болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.10. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд амьдрах орчны аюулгүй байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 59.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 51.2% нь дунд зэрэг, 20.7% нь сайн, 18.2% нь муу, 9.9% нь маш муу, 0.0% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 15. Амьдрах орчны аюулгүй байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 9 аж ахуй нэгж аюулгүй ажилгааны хууль дүрмийг баримтлан ажиллах, 6 аж ахуй нэгж стандартаа тодорхой болгох, мөрдүүлэх, 5 аж ахуй нэгж дэд бүтэцийг сайжруулах, тус бүр 3 аж ахуй нэгж орон нутагтай хийх хамтын ажиллагааны гэрээнд нарийвлан тусгаж өгөх, сургалт зохион байгуулах тус бүр

2 аж ахуй нэгж төвлөрлийг тараах нь амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулна, ААН-ийн хариуцлагаас шалтгаална, стандарт зөрчигдөхөд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, орчин үеийн технологийг нутагшуулах гэх мэтээр хариулжээ.

Зураг 15.1 Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 25.7 %-ийг аюулгүй ажилгааны хууль дүрмийг баримтлан ажиллах гэсэн санал эзэлж байна.

### 3.11. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛ


Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд газрын харилцааны зохицуулалтын байдал дунджаас дээгүүр буюу 55.7% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.4% нь дунд зэрэг, 22.3% нь муу, 20.8% нь сайн, 10.0% нь маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 16. Газрын харилцааны зохицуулалтын байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 13 аж ахуй нэгж газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд суртачилж таниулах, 6 аж ахуй нэгж байгууллага хоорондын уяалдааг сайжруулах, тус бүр 3 аж ахуй нэгж хүнд суртлыг арилгах, орон нутгийн оролцоог багасгах, давхардсан олон зөвшөөрөл авдаг байдлыг болих шаардлагатай, тус бүр 2 аж ахуй нэгж газрын төлбөрийн гэнэтийн өсөлт мөн давхар төлбөр төлөхийг зогсоох, газрын харилцааны байгууллагуудыг нэгдсэн системтэй болгох, 1 аж ахуй нэгж газар олголтыг нэг цэгт төвлөрүүлэх гэх мэтээр хариулжээ.

Зураг 13.1 Газрын харилцааны зохицуулалтыг сайжруулах санал



Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 39.4%-ийг газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд суртачилж таниулах гэсэн санал эзэлж байна.

### 3.12. ТӨР ЗАСГИЙН ЗҮГЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ дунджаас доогуур буюу 46% байна. Нийт судалгаанд оролцогсодын 35.4% нь дунд зэрэг, 33.8% нь муу, 20.8% нь маш муу, 10.0% нь сайн, 0.0% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 17. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 14 аж ахуй нэгж ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах, 10 бодлогоор дэмжих, тус бүр 2 аж ахуй нэгж орон нутгийн эрх мэдлийг хязгаарлах, нэгдсэн нэг тогтвортой хуультай болох, тус бүр 1 аж ахуй нэгж засгийн газрын буруу бодлого мөн тогтворгүй байдал, гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг дахин хэлэлцэх, төрийн албан хаагчид ажил үүргээ цаг тухайд нь хийдэг болох, бодлого тогтвортой байх, банкны хүү хэт өндөр, хуулийн орчинг тогтвортой болгох гэх мэтээр хариулжээ.

Зураг 17.1 Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 41.2%-ийг бодлого тогтвортой байх гэсэн санал эзэлж байна.

### 3.13. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ дунджаас дээгүүр буюу 53.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 30.8% нь дунд зэрэг, 10.8% нь муу, 36.9% нь сайн, 16.9% нь маш муу, 4.6% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 18. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 13 аж ахуй нэгж хамтарч ажиллах, 12 хуулиа дагаж мөрдөх мөн сайжруулах, тус бүр 6 аж ахуй нэгж мэдээ мэдээллийг суртачилж таниулах, орон нутагт хамаагүй эрх мэдлийг олгохгүй байх, 3 аж ахуй нэгж авилгын асуудал, 1 аж ахуй нэгж орон нутгийн удирдлага болон Яамнууд байгууллагуудын уяалдаа маш муу гэх мэтээр хариулжээ.

Зураг 18.1 Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 31.7%-ийг хамтарч ажиллах гэсэн санал эзэлж байна.

### 3.14. НУТГИЙН ИРГЭД УУЛ УУРХАЙН КОМПАНИ ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааны үнэлгээ дунджаас доогуур буюу 48.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 25.4% нь дунд зэрэг, 23.8% нь муу, 24.6% нь маш муу, 23.8% нь сайн, 2.3% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 19.Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааны үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 20 аж ахуй нэгж уул уурхайн салбарыг таниулах, суртачилах, ойлгуулах, 8 аж ахуй нэгж хамтарч ажиллах, тус бүр 5 аж ахуй нэгж орон нутгийн эрх мэдлийг багасгах хэрэгтэй, нэгдсэн бодлоготой болох, 4 аж ахуй нэгж иргэд хуулиа дагаж мөрдөж ухамсарлах, хуулийн мэдлэг олгох, 2 аж ахуй нэгж орон

нутгийн эрх мэдлийг багасгах хэрэгтэй, 1 аж ахуй нэгж иргэдтэй нээлттэй харилцах хамтарч ажиллах гэх мэтээр хариулжээ.

Зураг 19.1 Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 44,4%-ийг уул уурхайн салбарыг таниулах, суртачилах, ойлгуулах гэсэн санал эзэлж байна.

### 3.15. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ХЯЛБАР БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ дундаж буюу 52.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 34.6% нь дунд зэрэг, 25.4% нь муу, 17.7% нь маш муу, 21.5% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 20. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 17 аж ахуй нэгж цахим болгох, 6 аж ахуй нэгж ил тод тогтвортой байх, 5 аж ахуй нэгж үйлчилгээг хуулийн хугацаанд хурдан шийдвэрлэх, тус бүр 2 аж ахуй нэгж хэт олон давхардсан шат дамжлагыг зохицуулах, хүнд суртал, ашиг сонирхолын зөрчил, хууль эрх зүйн тогтвортой байдал, хууль эрх зүйн орчинг сайжруулах, орон нутгийн иргэдийн оролцоог багасгах гэх зэргээр хариулсан байна.

*Зураг 20.1 Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах ажиллагааг хялбаршуулах санал*




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 44.7%-ийг цахим болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.16. НИЙГМЭЭС УУЛ УУРХАЙД ХАНДАХ ХАНДЛАГА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ дунджаас доогуур буюу 44.8% байна. Нийт судалгаанд оролцогсодын 37.7% нь муу, 26.2% нь маш муу, 31.5% нь дунд зэрэг, 4.6% нь сайн, 0.0% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 21. Нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 16 аж ахуй нэгж нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх,

10 аж ахуй нэгж нийгмийн хандлагыг өөрчлөх, тус бүр 6 аж ахуй нэгж хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль бус олборлолтыг зогсоох, 2 аж ахуй нэгж хуулиар тодорхой нэгдсэн бодлоготой болох гэх мэтээр хариулжээ.

Зураг 21.1 Нийгмээс уул уурхайд хандах хандлагыг сайжруулах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 39.0%-ийг нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх гэсэн санал эзэлж байна.

### 3.17. АВЛИГААС АНГИД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас авлигаас ангид байдлын үнэлгээ дундаж буюу 52.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 39.2% нь дунд зэрэг, 20.0% нь муу, 12.3% нь маш муу, 25.4% нь сайн, 3.1% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 22. Авлигаас ангид байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 8 аж ахуй нэгж нээлттэй ил тод болгох, 6 аж ахуй нэгж хяналт гүйцэтгэл хариуцлага муу байгаагаас авилга үүсч байна, 5 аж ахуй нэгж хүнд сурталгүй ажиллах, 4 аж ахуй нэгж цахим болгох, 3 аж ахуй нэгж Хуулийн дагуу ажиллах хэрэгтэй, тус бүр 2 аж ахуй нэгж сонгон шалгаруулалт сайн хийх үйл явцийг сайжруулах, орон нутгийн оролцоог багасгах, авилгал өгөхгүй бол шат бүрдээ хүнд суртал гардаг, авилга авсан албан хаагчид ногдуулах арга хэмжээг чангатгах, 1 аж ахуй нэгж хууль эрх зүйн орчинг сайжруулах гэх мэтээр хариулжээ.

Зураг 22.1 Авлигаас ангид байлгах санал




Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 22.9 %-ийг нээлттэй ил тод болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.18. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮРЭЛЦЭЭ, ЧАНАР

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 64.8% байна. Нийт судалгаанд оролцогсодын 37.7% нь дунд зэрэг, 50.8% нь сайн, 5.4% нь муу, 4.6% нь маш сайн, 1.5% нь маш муу гэж хариулсан байна.

Зураг 23. Туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ



### 3.19. ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИХ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ дундаж буюу 50.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 38.5% нь дунд зэрэг, 30.0% нь муу, 9.2% нь маш муу, 21.5% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 24. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ



#### 4. ДҮГНЭЛТ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны 2021 оны байдлыг судалж үзээд дараах дүгнэлтэд хүрлээ.

- Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ **54.1** оноо буюу **“ДУНД”** гэсэн үнэлгээтэй байна.
- Үнэлгээг нэгтгэн гаргасан 19 үзүүлэлтээс “маш сайн”, “сайн” гэсэн үнэлгээ гараагүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчин таатай гэж үзэх боломжгүй байна. Мөн “маш муу” гэсэн үзүүлэлт илрээгүй нөхцөл байдал хэт хүндрээгүй байгааг илтгэж байна.
- Хамгийн муу үзүүлэлт нь “Улс төрийн тогтвортой байдал” болсон шалтгаан нь сүүлийн жилүүдэд улс төрийн гэнэтийн шийдвэрүүд гарч, төрийн үйл ажиллагаа тогтвортой явахгүй, залгамж чанараа алдаж, төр засаг солигдох болгонд шинэ бодлого, хууль эрх зүйн орчин бий болж, урт хугацааны төлөвлөгөөтэй бодлого байхгүй, салбарыг мэргэжлийн бус хүн удирдаж, төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа болон сонгууль дөхсөнтэй холбоотой улс төржилт нэмэгдсэнээс болсон.
- Дараагийн тааруухан үзүүлэлтэд “Нийгмээс уул уурхайн салбарт хандаж буй хандлага” орж байгаа нь ард иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл очихгүй, улс төрч, төрийн бус байгууллага худлаа, буруу мэдээлэл түгээж, популизм хийж байгаагийн зэрэгцээ хууль бус олборлолт, нөхөн сэргээлт хийдэггүй, хариуцлагатай уул уурхайг хангалттай хэмжээнд хөгжүүлэхгүй байгаатай холбоотой.
- Муу ангилал дотроо гайгүй үзүүлэлтэд “Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж” ороход мэдээлэл хангалтгүй, “Авлигаас ангид байдал”-д хүнд суртал ихтэй, “Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал” ороход олон шат дамжлагатай, “Дэд бүтцийн хөгжил” сул байгаад төмөр зам, вагон дутагдалтай, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхгүй, автозам барилт, түүний засвар үйлчилгээ тааруу байгаа зэрэг голлох шалтгаанууд нөлөөлсөн байна.
- Дунд ангиллын доогуур жагсаж байгаа үзүүлэлтэд газрын мэдээллийн нэгдсэн системгүй, орон нутгийн оролцоо ихтэй, мэдээлэл сурталчилгаа муутай байдлаар “Газрын харилцааны зохицуулалт”, орон нутгийн удирдлага хэт их эрх мэдэлтэй, мэдээлэл дутмаг, хууль сахидаггүй, авилгын асуудалтай байдлаар “Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж”, хуулиуд хоорондын болон дүрэм, журмын уялдаа холбоо муу, мэдээлэл, сурталчилгаа тааруу, тодорхойгүй байдал ихтэй зэргээс шалтгаалж “Уул уурхайн үйл ажиллагааны болон Байгаль орчны хууль, дүрэм журмын тодорхой байдал” гэсэн үзүүлэлтүүд багтлаа.
- Татварын орчин тогтворгүй, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр өндөр зэрэг нь “Уул уурхайн татварын орчин”-г, Аюулгүй ажиллагааны

хууль, дүрмийг баримталдаггүй, стандарт тодорхойгүй шалтгаан нь “Амьдрах орчны аюулгүй байдал”-ыг дунд ангилалд оруулсан.

- “Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж” нь мэдээлэл нь цахимжиж онлайн болоогүй, “Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал” нь ажиллах хүчийг чанартай бэлтгэх тал дээр тааруу байгаа, “Туслан гүйцэтгэгчийн хүртээмж, чанар” нь гэрээний үүргээ чанартай биелүүлэх хэрэгтэй болсноор, “Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал” нь хяналт, баталгаажуулалт тааруу, мэргэжлийн хүнээр чанартай хийлгэхгүйг байгаагаас болж дунд үзүүлэлтийн боломжийн төвшинд эрэмбэлэгджээ.

## 5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин 2021 оны байдлаар **“Дунд”** үнэлгээтэй болон үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь “маш сайн”, “сайн” үнэлгээнд хүрээгүй байгаа тул хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлагатай бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

- Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулахын тулд төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, сайжруулж, урт хугацааны хөгжлийн бодлого гарган, түүнийгээ хайзахгүй хэрэгжүүлэх механизмийг бий болгох шаардлагатай. Салбарын үйл ажиллагааг нам, улс төрийн үйл ажиллагаанаас хамаарал багатай байлгахыг хичээж, Засгийн газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулахад анхаарч, төрийн албан хаагчдыг өөрчилдөггүй болгож, удирдах өндөр албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, улс төрчид, иргэний хөдөлгөөний хариуцлагыг өндөржүүлж зохицуулах шаардлагатай.
- Олон нийтэд үнэн, бодит, салбарын талаар эерэг ойлголтыг өгөх мэдлэг, мэдээлэл өгөх сургалт, сурталчилгаа, PR-ийн ажлыг тогтмол зохион байгуулах, салбарын мэргэжилтнүүдэд зориулж ашигт малтмал, байгаль орчин, газрын харилцаа болон бусад холбогдох хууль эрх зүйн орчны талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааг нэгдсэн байдлаар ил тод, энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргүүлдэг онлайн платформыг бий болгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байгаа хариуцлагагүй, хууль бус олборлолт хийдэг, нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлдэггүй иргэд, байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох, хариуцлагыг хүлээлгэх ажлыг холбогдох хүчний байгууллагатай хамтран гүйцэтгэх.
- Аливаа гэнэтийн шийдвэр гаргахаас зайлсхийж, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх, мэдээллээр хангаж ажиллах.
- Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэх үүднээс шаардлагатай мэдээллийг интернетийн орчинд байршуулж, тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрөл олгох ажиллагааны шат дарааллыг багасгаж, цахимаар өргөдөл хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх.
- Геологийн мэдээллийг цахимжуулж хөрөнгө оруулах сонирхолтой этгээдийг бодит мэдээллээр шуурхай хангаж, геологи хайгуулын ажлын хяналт, баталгаажуулалтын ажлыг сайжруулах тал дээр дэвшилтэт техник, технологийг ашиглаж, өндөр мэдлэг, туршлага бүхий хүмүүсийг оролцуулах боломжтой.
- Татварын орчны давхардал, бодит бус татвар ногдуулалт, тодорхойгүй байдлыг арилгахад анхаарч татвар, санхүүгийн холбогдох төрийн

байгууллагуудтай хамтран ажиллаж, татварын орчныг таатай болгоход анхаарч ажиллах.